



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 256

Улаанбаатар хот

Санхүүжилт шийдвэрлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.8, 14.2.2, 14.2.3, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулсан хөнгөлөлттэй зээлийн гэрээний 5.03 зүйлийн "Г" заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний оношилгоо эмчилгээний төв байгуулах төслийн хөрөнгөөс тус төслийн хүрээнд хийж гүйцэтгэх туслах барилга байгууламжууд, тэдгээрийн дэд бүтэц, гадна тохижилт, инженерийн шугам сүлжээний зураг төслийн ажлыг 89,244,172 /наян есөн сая хоёр зуун дөчин дөрвөн мянга нэг зуун далан хоёр/ төгрөг, кадастрын зургийн зөвлөх үйлчилгээг 8,400,903 /найман сая дөрвөн зуун мянга есөн зуун гурван/ төгрөг, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахад хуулийн зөвлөх үйлчилгээ авах зардлыг 10,000,000 /арван сая/ төгрөг, зөвлөхийн өрөөний урсгал засварын ажлыг 15,851,920 /арван таван сая найман зуун тавин нэгэн мянга есөн зуун хорин/ төгрөгийн төсөвт өртөгийг тус тус баталсугай.

2. Туслах барилга байгууламжууд, тэдгээрийн дэд бүтэц, гадна тохижилт, инженерийн шугам сүлжээний зураг төсөл, зөвлөхийн өрөөний урсгал засварын ажил, кадастрын зураг хийлгэх, хуулийн зөвлөх үйлчилгээ авах үйл ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Санхүү, эдийн засгийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т. Баярсайхан/-д даалгасугай.

3. Туслах барилга байгууламжууд, тэдгээрийн дэд бүтэц, гадна тохижилт, инженерийн шугам сүлжээний зураг төсөл, зөвлөхийн өрөөний урсгал засварын ажил, кадастрын зураг хийлгэх, хуулийн зөвлөх үйлчилгээ авах үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э. Оюунсүрэн/-д даалгасугай.

САЙД



Г. ШИЙЛЭГДАМБА

080870